

Сосорбарамын Хүрэлсүх[✉]

¹Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн,
Монгол улс, Улаанбаатар-13330, Энхтайвны өргөн чөлөө,
Шинжлэх Ухааны Академийн хүрээлэнгүүдийн нэгдсэн I байр

XVI зууны үед холбогдох хадны оршуулгууд¹

Хураангуй. Хадны оршуулгын дурсгал нь манай улсын Алтай, Хангай, Хэнтий, Говийн уулсаар тархсан байдаг. Илэрч олдсон дурсгалын дийлэнх нь дундад зууны үе буюу XIII-XIV зууны үед холбогддог бөгөөд энэ үе гэхэд оршуулгын зан үйл нь нийтлэг ашигладаг оршуулгын хоёр хэлбэрийн нэг болж байжээ. Энэхүү өгүүлэлд Ховд аймгийн Дуут сумын нутаг Шар булгийн ам, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Авдрант хайрхан уул зэрэг хадны 2 оршуулга хамрагдсан ба АНУ-ын Мичиганы Их Сургуулийн “Ancient Protein and Isotope” лабораторид хийсэн радиокарбоны шинжилгээгээр XVI зууны үед холбогдох дурсгал болохыг тодорхойлсон юм. Тухайлбал, Шар булгийн амны оршуулга НТ 1503-1598 буюу дундаж магадлалаар 1558 он, Авдрант хайрхны оршуулга НТ 1471-1634 буюу дундаж магадлалаар 1564 оных гэж гарчээ. Он цагтай холбогдуулан товч өгүүлэхэд монголын үеийн булш оршуулгын дурсгалыг эхэн үе, сонгодог үе, хожуу үе хэмээн ангилан авч үздэг бөгөөд дээрх хоёр дурсгал хожуу үеийн ангилалд хамаарах ба Монголд Буддын шашны III удаагийн дэлгэрэх үйл явц өрнөж, оршуулгын зан үйлд гүнзгий өөрчлөлт орсон цаг үетэй мөн давхцаж байгаа төдийгүй эл үеийн монголчуудын оршуулгын соёлын судалгаанд хувь нэмэр бүхий эх сурвалж болох юм.

Түлхүүр үг: Хадны оршуулга, XVI зууны монголчууд, оршуулгын зан үйл, радиокарбоны шинжилгээ

Khurelsukh Sosorbaram[✉]

¹Institute of Archaeology,
Mongolian Academy of Sciences Building-1,
Peace avenue, Ulaanbaatar-13330, Mongolia

Rock burials in the dated 16th century

Abstract. Rock burial monuments are distributed across the Altai, Khangai, Khentii, and Gobi mountain ranges of Mongolia, representing a funerary tradition practiced by ancient nomads for approximately two millennia. The vast majority of discovered sites date back to the Middle Ages, specifically the 13th and 14th centuries. By this period, rock burial had already evolved into a well-established and widely practiced ritual, becoming one of the two primary forms of interment. This article examines two specific rock burials: one from the Shar bulag valley in Duut Soum, Khovd Province, and another from Avdrant khairkhan Mountain in Nomgon Soum, Umnugovi Province. Radiocarbon dating has identified these sites as belonging to the post-Imperial period, specifically the 16th century. The findings from these burials coincide with the era when Buddhism spread throughout Mongolia, leading to profound transformations in funerary customs. Thus, they serve as vital primary sources for the study of Mongolian burial culture during this transitional period. We have had samples from rock burials subjected to dating analysis (14C) in the the Ancient Protein and Isotope Laboratory at the University of Michigan. As a result, Shar bulag AD 1503-1598, median probability AD 1558. Avdrant khairkhan AD 1471-1634, median probability AD 1564. Briefly, in relation to time, mongol burials are classified into the early period, the classical period, and the late period. The two burials mentioned above belong to the late period category. It will be a source of contribution to the study of the burial culture of the Mongols of this era.

Keywords: Rock burial, 16th century Mongols, funerary practices, radiocarbon dating

¹ Энэхүү өгүүлийг ШУТС-гийн санхүүжүүлсэн “Монголын эзэнт гүрний археологи” цогц судалгаа захиалгат төсөл (ШУУЗ-2022/286)-ийн хүрээнд гүйцэтгэв.

Удиртгал

Эртний монголчуудын оршуулгын зан үйлийн нэг болох хадны оршуулгын дурсгал манай улсын нутгаас илэрч олдсоор байна. 2020 онд Ховд аймгийн Дуут сумын нутаг Шар булгийн амны оршуулга, 2021 онд Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Авдрант хайрхан уулын хадны оршуулгыг нутгийн хүмүүсийн мэдээллийн мөрөөр судлаачид газар дээр нь очиж малтан шинжилсэн юм. Малтлагаар Шар булагийн амны хадны оршуулга хөндөгдөөгүй, Авдрант хайрхны хадны оршуулга тоногдсон байдлаар илэрсэн юм. Уг хоёр дурсгалыг өмнө нь “Монголын археологийн өв” цувралын XIII боть “Монголын хадны оршуулгын дурсгал” эрдэм шинжилгээний каталогт бүрэн гүйцэд бус маш товчхон нийтлүүлж байсан (Хүрэлсүх нар 2022, 233-241, 244-251). Харин энэ удаа эрдэм шинжилгээний арга зүйн дагуу дэлгэрүүлэн авч үзэж радиокарбоны ^{14}C -ийн шинжилгээний үр дүнг хамтатган судалгааны эргэлтэд оруулж байна.

Малтлага судалгаа

Шар булгийн амны хадны оршуулга. Уг дурсгал нь Ховд аймгийн Дуут сумын төвөөс баруун хойш 38 км зайд байрлана. Хар хавцал эхээсээ ам хүртлээ эгц налуу, цавчим, цухал бөгөөд нарийн гол хавцлаар урсана. Энд айл нутаглах боломж бага тул хүн мал явахгүй нэлээн эзлүүд нутаг аж. Хавцалын дунд биед хошуу маягтай түрж орсон хадан уулын оройд дэл маягтай ханан

хадны нарийн ангалд оршуулга үйлдсэн (Зураг 1) байсныг малтан шинжиллээ (Хүрэлсүх нар 2020, 26). Хадны ангал зүүн урдаас баруун хойш чиглэсэн ба дарсан чулууд нь он цагийн уртад нуржээ. Ангал руу өнгийж үзэхэд гэрийн хана болон шарилыг тээж авчрахад ашигласан нарийн шургааг модыг уртааш тавьсан ба ангалын баруун хойно гавлын ясыг чулуун дээр ил гаргажээ (Зураг 2а). Чулууг бага зэрэг зайлуулж үзэхэд эмээлийн урд бүүрэг, гэрийн ханын хугархай модыг гаргаж хаясан байсан ба хэмжилт хийж үзэхэд хадан ангал 2,2 м урт, 40-50 см өргөн, 3,8 м өндөртэй. Хадны ангал баруун хойд талаасаа ханан хадтай тул зөвхөн зүүн урд талаас нь малтах боломжтой.

Ил байсан багана болон ханын модыг хашиж дарсан чулуутай авч шалгаж үзэхэд гэрийн ханын ихэнх нь суран үдээртэйгээ (Зураг 6б), ачлага (Зураг 6а) бололтой модны ёзоорыг ташуу тайрсан ба дунд хэсэгт нь зэрэгцүүлж 6 удаа зурсан байна. Малтлага хийж буй тал буюу ангалын зүүн урд талаас эмээлийн бололтой төмөр хадаастай гуулин хярын хугархай, цааш малтахад (ханын мод болон чулууг бүрэн авсны дараагаар) зүүн урдаас хүний хүзүү болон сээрний 2-3 нугалам яс гарч хүний бусад яс ерөнхийдөө хөндөгдөөгүй байдлаар илрэв. Гавал хөдөлсөн хэдий ч талийгаачийн толгой дор эхлээд модон сам (Зураг 5а), 2 янзын модон дөрөө (Зураг 4б), түүнийхээ дээр төмөр тоноглолтой эмээлийн модоор (Зураг 3) дэр тавьсан байв. Хүнээ тэнэгэр байдлаар дээш харуулан, толгойг зүүн урагш буюу



Зураг 1. Оршуулга илэрсэн хадны ангал



а



б

Зураг 2. а. Оршуулгыг чулуугаар дарсан нь, б. Оршуулгыг малтаж гаргасан нь

хавцлын нарийн голын эх өөд хандуулсан. Баруун гарыг их биеийн дагуу уртааш нь, зүүн гарын их биеийн дагуу уртааш тавиад сарвууг аарцган дээр тавьсан. Хоёр хөлийг нугалж атийлгалгүй шулуун жийлгэсэн (Зураг 2б). Оршуулгын гол хэсгээс хувцас өмсгөлийн үлдэгдэл бололтой үслэг амьтны маш бага хэмжээтэй тасархай, ташааны зүүн талд хаданд наалдуулан савны модон тагийг (Зураг 5б) хажуугаар нь босгож, баруун хөлийн гадна шилбэний харалдаа богийн шилбийг босгож, зүүн хөлний гадна төмөр тоноглолтой бүтэн суран

хазаарын (Зураг 4а) хэсэг уртааш маягтай, хүний хоёр шилбэ ясны дунд богийн шилбэ ясыг уртааш тус тус тавьжээ. Талийгаачийн аарцагт өмд (Зураг 4в) бололтой хадгалалт муутай арьсан хувцасны тамтаг үлдсэн. Хоёр хөл арьсан гуталтайгаа (Зураг 5в). Хүний хөлийн өсгийний дороос төмөр амгай гархин зуузайтай давхар суран хазаар уртааш тавьсан ба шил хэсэг нь зүүн шилбэний гаднаас цухуйна. Хажуугаас нь нарийхан урт хүрэл эдлэлийн хугархай, сураар сүлжиж байсан оромтой модны хамт илэрсэн.



Зураг 3. Төмөр тоногтой эмээлийн модны хэсгүүд



Зураг 4. а. Гархин зуузаатай суран хазаар, б. Модон дөрөөний хугархай хэсгүүд, в. Арьсан өмдний залгаасыг шөрмөсөн утсаар оёсон нь.



Зураг 5. а. Модон самны хугархай, б. Савны модон таглаа, в. Арьсан гутлын үлдэгдэл

Олдворын тодорхойлолт. **Төмөр тоногтой модон эмээл.** Эмээл урд бүүрэг, зөв, буруу талын хавтас, хойд бүүрэг тус бүрээрээ салсан. Арай бүтэндүү зөв талын хавтас 45 см урт, 15 см өргөнтэй, 2 см зузаантай. Хавтасны урд ирмэгт

тэгш өнцөгт хэлбэртэй хавтгай нимгэн төмрийг олон жижиг нүхтэй болгож цоолсон ба түүн дээрээ гархи унжуулсан хадаасаар хавтастай нэвт хадаж бөхөлсөн байв.



Зураг 6. Ориуулгад ашигласан а. Ачлага мод, б. Ханын мод, в. Унины хугархай хэсгүүд

Хавтасны хойд захад урт нарийн төмрөөр хавтсыг бөгжлөх маягаар бараг бүтэн ороож голд нь төмөр хадаасаар нэвт хадаж, түүний ард цоожны цуурга мэт (нугас адил хөдөлж байх) дундаа нүхтэй төмрийг 2 үзүүрт нь хадаж бөхөлжээ. Буруу талын хавтас ихэд муудсан. Хавтасны хойд захад зөв талын хавтастай адил төмөр тоноглолтой. Хоёр хавтсанд дөрөөний сурны нүхний ором тод мэдэгдэнэ. Хавтаснууд урд, хойд бүүрэгтэй холбож үдэх угсуургын олон жижиг нүхтэй. Урд бүүрэг нь хагарч, эмтэрч, зүсэж тэгшилсэн оромтой, 20,5 см урт, 16 см өндөр, 5 см зузаантай. Босоо дөрвөлжиндүү хэлбэртэй. Хоёр хавтсанд холбогдох үдээрийн 4 нүхтэй. Хойд бүүрэг нь дугуй далбагар хэвтээ хэлбэртэй, 25 см урт, 12 см өндөр, 2,5 см зузаантай. Ихэд хагарч эмтэрсэн. Хойд бүүргийн ирмэгийг тойруулан хооронд нь зайтайгаар 6 хэсэг газарт 1 см өргөнтэй нимгэн гуулиар хагас бөгжилж төмөр хадаасаар нэвт хадаж бөхөлсний 3 нь үлдэж хоцорчээ.

Эмээлийн гуулин хяр. Хэсэгчилж хадан, эмжиж байсан бололтой хоёр үзүүртэй хадаасны нүхтэй, 9 см болон 11 см урттай 2 ш олдсон ба нэг нь 0,9 см нөгөө нь 1,4 см өргөнтэй, 0,15 см зузаантай. Хоёуланд нь 3 нүх (хоёр үзүүр болон голд нь) гаргаж төмөр хадаасаар хадаж байсан хадаасны үлдэгдэлтэй.

Модон дөрөө - 1. Таван хэсэг болж хугарсан. Ганц бүтэн нь углуургын сэтэрхий нүх гаргасан таваг. Дөрөөг хугарсан ормоор нь эвлүүлэн сэргээж үзэхэд 20 см өндөр, 13 см өргөн, сэнж хэсэгтээ 2 см, таваг хэсэгтээ 4 см зузаантай. Тавагнаас доош 3,4 см урт сэртгэнтэй (Зураг 4б).

Модон дөрөө - 2. Уг дөрөө 26 см өндөр, 15,5 см өргөн, 2,5 см зузаантай. Тавгийг их биеэс нумруулан матсан ба сэнж хэсэгтээ өвөрмөц шийдэлтэй. Сэнжийг гурвалжлан гаргасан ба гадна талын дээд үзүүрт нь (тагнай татах) ховил гаргаж ухсан (Зураг 4б).

Төмөр тоногтой давхар суран хазаар. Хазаар 0,8 см зузаан, 4 см голчтой гархин зуузайтай. 14,5 см урт, 1 см өргөн амгайтай. 1,2-1,5 см өргөн давхар сураар хийсэн. Хамрын хөндлөн холбоос тасарсан ба зуузайнаас авсан залгаас дээр урт нарийн төмөр тоноглолтой. Хамар болон сагалдаргын залгаасанд 1,5 см голчтой товгор чимэглэлтэй. Сагалдаргын уяаг өнөө цагийн уядагтай адил байна. Хазаар жолоогүй (Зураг 4а).

Үслэг амьтны арьсны тасархайнууд. Үүнд: 1. Тарваганы арьсны тасархай. Үрчийж хатсан, 9x8 см хэмжээтэй. 2. Арьс нь зузаавтар, үс нь барагцаалдахад чоно, үнэгний үстэй төстэй шаргал сортой. 10x10 см хэмжээтэй хоёр тасархай бий. 3. Арьс нь харалж хатсан. Зүйж залгаж оёсон оёдолтой. Үс сор, өнгө сайтай. Магадгүй булга, халиу, суусар байх боломжтой. 4. Арьс нь цайж

хатсан. Үс нь маш нарийн ноолуур маягтай. Нөгөө хэдэн үслэг арьсны тасархайнаас эрс ялгагдана. 12x6 см хэмжээтэй. Эдгээрийг юунд хэрхэн ашиглаж байсныг нь тодорхойлох боломжгүй ч үслэгнийх байдлаар ямар амьтны болохыг тодорхойлох бүрэн боломжтой.

Арьсан өмдний үлдэгдэл. Аарцгийн ястай наалдаж хатсан. 26 см x 16 см хэмжээтэй тамтаг төдий зүйл үлдсэн байна. Төдүүл хэсэгтээ 11 үетэй болон тэгш гадаргуутай арьсны амийг нийлүүлж босоо шулуун оёог шөрмөсөн утсаар нийлүүлж оёсон тасархайтай (Зураг 4в).

Арьсан гутал. Хос арьсан гутал нь хүний хөлд өмсөөтэй байдлаар илэрсэн. Гутлын хоншоор хэсэг бүтэн, өсгий, боом, түрий хэсэг үжирч үрэгдсэн. Зөвхөн хоншоор хэсгээс залгаасыг, оёдол болон улны талаар л товч тодорхойлох боломжтой. Зүүн хөлийн гутлын урт 19 см, өндөр 14,5 см хэмжээтэй байна. Хоншоор нь шөвгөр загвартай. Хоншоорын голоор 2 хацрын амыг шулуун нийлүүлж голоор нь нарийн оруулга оруулан дотогш нь оёсон. Уланд шир давхарласан ба хоншоорын адил нарийн оруулга оруулан бүдүүвтэр шөрмөсөн утсаар ил оёсон. Улны уртыг тодорхойлох боломжгүй. Өргөн 7 см. Ширний зузаан 5 мм байна. Баруун хөлийн гутал хаданд дарагдаж шалчийсан. Зүүн хөлийн гуталтай адил эсгүүр загвартай. Ширэн ултай. Харин гадна хажуу буюу боомын хэсэгтээ босоо залгаастай. Нөгөө гуталтай адил бүтэн бус. Одоогийн байгаа хэмжээ нь 18 см урт, 12 см өндөртэй (Зураг 5в).

Модон сам. Эмээл, дөрөөний хамт толгой дор дэр болгон тавьсан. Уг сам бүтэн бус хугарсан. 8,3 см урт, 4,3 см өргөн, 1,5 см зузаантай. Нийт 16 шүдтэй (Зураг 5а).

Суулгын модон таг. Таг 11 см голчтой. 1,7 см өргөн мөртэй. Мөрөнд 5 мм ирмэг гаргасан. Гадна хүрээндээ 3,6 см урт, 2 см өргөнтэй албаар тэгшилж зассан сэтэрхийтэй. Шингэн зүйл гарах зориулалттай байх магадлалтай. Нэг өвөрмөц тал нь таглааны голд 3,7 см голчтой давхар жижиг таглаатай. Уг жижиг таглааг бүдүүн олсон утсаар ороож жийрэглэн тагласан (Зураг 5б).

Сүлжмэлийн тасархай. Хатсан учир үйрч бутарсан. Сур лав биш. Бодоход ургамлын иш байх магадтай. 10 см урт, 1,4 см зузаантай.

Гуулин эдлэл. Нарийн урт дөрвөлжин хэлбэртэй. Голдоо хөндий бус цул. 12,5 см урттай. 7 мм өргөн, 7 мм зузаантай. Бага зэрэг нумарсан маягтай. Нүүрэн талдаа тэг дундаа үл мэдэг ховил татсан. Өөр элдэв хээ чимэггүй. Хоёр үзүүрийг тэгшилж зассан. Үүрэг зориулалт тодорхойгүй.

Модон иш. Алх маягийн төмөр багаж суулгаж байсан ором модонд үлдсэн. 23 см урт, 1,7 см өргөн, 1,5 см зузаантай. Гуулин эдлэлийн хамт илэрсэн.

Гэрийн ханын мод. 10-77 см урттай 20-оод ханын хугархай гарсан. Дунджаар 2,2 см өргөнтэй, 1,1 см зузаантай. Ханын нүх хоорондын зай 15 см. Зарим ханын мод суран үдээртэйгээ хадгалагдаж үлдсэн (Зураг 6б).

Унь. Унины 4 ш хугархай ханын хамт илэрсэн. 12-40 см урт, 2,2 см зузаантай. 40 см урттай нь унины үзүүр хэсэг нь бөгөөд 0,5 см, хурц үзүүртэй (Энэ унины хурц үзүүрээс бодоход тоононы унь хатгадаг нүх нэвт байжээ) (Зураг 6в).

Ачлага мод. Эгц шулуун бус далий мурий. Урт 1,94 м, ёзоортоо 7 см зузаан. Үзүүрээсээ доошлох тусам өргөссөн. Модны ёзоорыг ташуу тайрсан (Зураг 6а).

Авдрант хайрхны хадны оршуулга. Өмнөговь аймгийн Номгон сумын Хармагтай багийн нутаг Авдрант хайрхан уул нь сумын төвөөс чанх баруунш 32 км зайд оршдог. Хавтгай тэгш оройтой, уулын орой хэсгийг тойрсон ханан

хадтай, уулын зүүн урд өвөрт ханан хадны хөмөгт эртний оршуулга (Зураг 7а) үйлдсэн байсныг тонуулчид тонож сүйтгэжээ (Хүрэлсүх нар 2021, 10).

Уг оршуулгыг тонуулчид ихэд сүйтгэсэн байгаа нь оршуулгын зан үйл, анхны тавилт зэргийг тодорхойлох боломжгүй болгожээ. Хадны оршуулгыг ханан хадны өвөрт баруун урдаас зүүн хойш чиглэлтэй хөмөгт тавьж хөмгийн амыг чулуугаар дарж тагласан байсныг тонуулчид чулууг нь нурааж, оршуулгыг сүйтгэн эд өлгийн зүйлс болон хүний ясыг гаргаж хаяжээ. Биднийг газар дээр очиход хөмгийн амны зүүн талд шарилд эсгий болон зэгс маягийн бүдүүн дэрс ашиглаж хийсэн дэвсгэрийг, баруун талд хүний яс, нумын хугархай, хос арьсан гутлын үлдэгдэл, төмөр гох, бүсний бололтой төмөр тоног, чимэглэл, сумны мөсний хугархай, даавууны жижиг тасархайнуудыг ил гаргаж хаяжээ (Зураг 7б).



Зураг 7. а. Ханан хадны өвөрт оршуулга үйлдсэн нь, б. Оршуулгыг тонуулчид тонож сүйтгэсэн байгаа нь.

Авдрантын оршуулгаас хөмгийн амны баруун талд тонуулчдын гаргаж хаясан хүний яс болон ил байсан арьсан гутлын үлдэгдэл (Зураг 11), хөх өнгийн даавуугаар өнгөлсөн модон чимэглэл, ясан наалттай нумын хугархай (Зураг 14), сумны мөсний хугархай, оршуулгад зүлджээ тавьсан хонины толгой, шарил тавьсан дэвсгэрийн үлдэгдэл (тамтаг) зэрэг эд өлгийн зүйлсийг баримтжуулсан ба хөмгийн амыг дарсан чулууг тонуулчид нураасан байсан бөгөөд чулууг зайлуулан нарийвчлан шалгаж, малтахад арьсан дээлийн үлдэгдэл (Зураг 8), суран бүсний төмөр тоноглол 11ш (Зураг 9-10), навчин хэлбэрийн төмөр зэв 1ш, нимгэн хавтгай ясан чимэглэл 1ш, урагдаж салбарсан даавуун уутны үлдэгдэл 1ш, хонины шийр 3ш, хавирга 3 ш гарсныг баримтжуулж авав. Тонуулчид хөмөгт юу ч үлдээлгүй шарилын дэвсгэрийг хүртэл гаргаж хаян бүгдийг нь сүйдэлжээ. Уг хадны оршуулгыг тонохоос өмнө харсан хүний дам яриагаар хөмөгт хүний зарим яс ил гарсан байсан бөгөөд анатомийн байрлалаараа

толгойг зүүн хойш хандуулсан байжээ. Шарилд авсны мод огт харагдаагүй гэв. Биднийг очиход уг оршуулгын зарим эд өлөг буюу эмээл (Зураг 12), модоор хийсэн матмал хос дөрөө (Зураг 13) алга болсон байсныг сурвалжлан нутгийн малчин Авдрант хайрхан хавиар өвөлжөөтэй Б.Отгонбаяр авч амбаартаа хадгалж байсныг олж тодруулав. Бид нутгийн малчин н.Мөнхжаргалаар газарчлуулан, ногоо бараадаж хаа байсан хол зайтай нутаглаж буй Б.Отгонбаярын очиж хадны оршуулгын дурсгал, түүний судалгааны ач холбогдол зэргийг түүнд ойлгуулан тайлбарлахад эртний түүх соёлын чухал олдвор бол өгөлгүй яах вэ хэмээн дуртайяа өгснийг Номгон сумын Соёлын төвийн эрхлэгч Ц.Нарангэрэлийг байлцуулан хүлээлцэж авав.

Олдворын тодорхойлолт. Эмээлийн мод. Эвдэрч салж унаагүй бүтэн. Эмээлийн урт 51 см, өндөр 26 см, өргөн 33,5 см. Урд, хойд бүүргийг хоёр хавтсанд зэрэгцүүлэн холбож, харалдаа 3 хос нүх гарган, тэр нүхээр үдээрийн сурыг

оруулан үдсэн. Урд бүүрэг шовгор босоо, хойд бүүрэг уужим налуу. Хоёр хавтас урдаа 2, ардаа 4 ганзаганы сурын нүхтэй. Буруу талын хавтас ардаа хагарсныг хоёр талд нь нарийн хавтгай төмөр харалдаа нь барьж, хоёр үзүүрт төмөр хадаасаар нэвт хадаж бөхөлсөн. Эмээлийн урд, хойд бүүргийн нүүрэн тал, хоёр хавтасны гадна хэсгийг улаавтар өнгийн будгаар шунхадсан. Хоёр хавтсанд дөрөөний сурны нүхтэй ба эдэлгээний ул мөртэй. Дөрөөний сурны нүхний харалдаа дор олом, жирмийн суртай. Урд бүүрэг нүүрэн талдаа 1,5 мм өргөнтэй зураасан (ховил) хээ, түүнийхээ дотор талд 1 см зайд 3 мм өргөнтэй товгор (хоёр талыг нь хонхойлгосон) хээгээр давхарлан хөвөөлсөн. Урд, хойд бүүргийн нүүрэн хэсгийн нумарсан хэсэгт 1,2 1,3 см өргөнтэй товгор эмжээрийг өөрөөс нь зорж гаргасан. Урд бүүрэг нүүрэн хэсэгтээ, хоёр хавтас урд үзүүртээ эмтэрсэн (Зураг 12).

Модон хос дөрөө. 1. Уг дөрөөг нягт хатуу, ширхэгтэй сухай модоор хийсэн. Хэмжээ 19,7 см өндөр, 13,4 см өргөн, сэнж хэсэгтээ 4 см, их болон таваг 1,5 см зузаантай. Тавгийг их биеэс нумруулан матсан ба сэнж хэсэгтээ өвөрмөц шийдэлтэй. Сэнжийг гурвалжлан гаргаж хоёр үзүүрийг нийлүүлэн төмөр хадаасаар хөндлөн нэвт хадаж бөхөлсөн. Дөрөөний таваг болон их бие адил 2,6 см өргөн, 1,5 см зузаантай. Сэнж хэсэгтээ 7,5 см өндөр, 4 см зузаантай. 2. Нөгөө хос дөрөөтэй хэлбэр, хэмжээний хувьд яг ижил. Уг дөрөөний нэг талын их бие болон таваг хэсэгтээ үжирч хагарч гэмтсэн (Зураг 13).

Модон хос эдлэл. 1. Уг эдлэл урт нарийвтар гонзгой хэлбэртэй. Урт 20,4 см, өргөн нэг үзүүртээ 6,8 см, нөгөө үзүүртээ 2,3 см, зузаан 1 см. Эдлэлийг хийхдээ хавтгай нимгэн модыг нэг үзүүрийг нь өргөн, нөгөө үзүүрийг нь нарийн гонзгой хэлбэрээр засаж бэлтгээд өргөн хэсэгт шаргал өнгийн даавууг хагас хулдаж наагаад гадуур нь хөх өнгийн даавуугаар давхарлан бүтэн хулдсан. Хөх өнгийн даавууны хоёр үзүүр урагдаж гэмтсэн. 2. Нөгөө хос эдлэл 18,5 см урт, 6,5 см өргөн, 1 см зузаантай. Нөгөөтэйгөө адил даавуугаар хулдсан ч үжирч гэмтсэн. Уг хос эдлэлийн өргөн үзүүрийн хоёр талд нь догол гаргасан ба доголын харалдаа ард жижиг нүх гаргасан. Энэ нүхийг ямар нэгэн юмнаас зүүж оосорлох зориулалтаар гаргасан байж мэднэ. Эл олдворын үүрэг зориулалтыг бүрэн тодорхойлох боломжгүй ч толгой, гэзэг үсний чимэглэлийн нэгэн хэсэг байж болмоор байна (Зураг 13б).

Суран бүсний төмөр тоног, чимэглэлүүд. Төмөр тоногууд таван янз бөгөөд хэмжээ нь харилцан адилгүй. Нугас бүхий төмөр тоног 3ш. Уг тоноглол 8 см урттай, 3,5 см өргөнтэй. Гархин унжлагатай нарийн чимэглэл 5 ш байна.

4 см өндөр, 1,8 см өргөнтэй. Төмөр тоноглолын заримынх нь дээд доод ирмэг дагуу нарийн хар сур буюу бүсийг хүрэл даравчтай төмөр хадаасаар нэвт хадаж бэхэлсэн. Уг тоноглолын дор 1,7 см голчтой гархи унжуулсан (Зураг 9-10).

Төмөр дэгээ. Дэгээ 8,2 см өндөр, 3,7 см өргөн, 2 мм зузаантай. Дэгээний хавтгай хэсгийн ард бүсний сурын адил хар өнгийн суран дээр барьж хүрэл даравчтай төмөр хадаасаар дээр 2, доор 1 нэвт хадаж бөхөлсөн. Дэгээнд давхарлан хадсан сурыг үзэхэд маш сайн боловсруулж, хар өнгийн будгаар будсан нь бүсний суртай яг адил байна (Зураг 10б).

Суран бүс бүхий төмөр арал. Төмөр арал 3,2 см урттай, 2,5 см өргөн, 3 мм зузаан. Хэлний урт 3,6 см. Аралд сурыг тогтоохдоо хүрлээр хийсэн дөрвөлжин хавтгай тав тавьж төмөр хадаасаар нэвт хадсан. Арлын хэлд бүсний сурыг холбож тогтоосон байдлаар хадгалагдаж үлдсэн. Сурны урт 10 см, өргөн 1,5 см.

Бүсний үзүүрийн төмөр чимэг. Уг чимэглэл 6,8 см урт, 3,5 см өргөн. Нүүрэн талд нь бүсний нарийн сурыг нэвт хадаж бөхөлсөн 3 төмөр хадаасны үлдэгдэлтэй. Ардаа төмөр хадаас нь хүрэл даравчтай (Зураг 10а).

Нумын хугархай. Нумыг бариул хэсгээр нь хугалсан. Урт 6,8 см, өргөн 4 см, зузаан 1,5-2 см. Модон үүсгэр дээр ясан наалттай, модон гичиртэй бөгөөд эх үүсгэрт нарийн ховил гаргаж суулгасан (Зураг 14а). Ясан наалтыг шөрмөсөөр ороосон. Шөрмөсөн дээрээ хүрэн өнгийн будгийн үлдэгдэлтэй. Нумын өрөөсөн хугархай үрэгдсэн бололтой малтлагаар илэрсэнгүй.

Төмөр зэв. Навчин хэлбэртэй. 9,4 см урттай, үүнээс 4 см сурвалжтай. Өргөн 3,2 см (Зураг 14б).

Сумны мөс. Бүтэн мөс үлдээгүй бүгд хугарч гэмтсэн. Хугарсан хэсгүүдээс үзэхэд 7-9 сумны мөс байсан бололтой нийт 24 ш урт, богино хугархай гарсан. Мөс 1 см голчтой. Нэг мөсний төгсгөл хэсэгт гурван талдаа өдний ул мөртэй. Өдний ормын урт 9,5 см, онь 4 x 5 мм. Мөсний төгсгөлд улаавтар өнгийн будгаар шунхадсан (Зураг 14в).

Арьсан дээлийн үлдэгдэл. Дээлийн үлдэгдэл ихэд салбарч урагдсан. Тоймтой хэмжиж тодорхойлох боломжгүй. Ямартай ч ханцуй болон товч шилбэний хоёр үлдэгдэлтэй. Ханцуйны мөрөөс тохой хүртэл хэсгийг нарийн хуниас маягаар эржийлгэсэн (Зураг 8).

Арьсан гутал. Гутал хадгалалт сайтай хэдий ч мэрэгч ихэд сүйдэлсэн. Зүүн хөлийн гутал нь их бие болон ул, өсгий бүтэн, гагцхүү түрий нь урагдаж салбарсан. Энэхүү бүтэн хэсгээс үзэхэд шөвгөр урт хоншоортой. Хоншоор болон өсгий нь голдоо буюу дундуураа нарийн оруулга бүхий залгаастай. Нимгэн ширэн ултай. Өсгий хэсэгт

гадна талдаа, өлмий хэсэгт дотогш нугалж оёсон шөрмөсөн утастай. Түрий нь ихэд урагдаж салбарсан. Хоёр давхар арьсаар хийсэн. Гутлын урт 27 см, улны өргөн 8 см, улны ширний зузаан 3 мм, түрийний өндрийг тодорхойлох боломжгүй. Баруун хөлийн гутлын ул болон өсгий хэсэг бүтэн, хоншоор түрий, их бие нь урагдаж тасарсан. Зүүн хөлийн гуталтай адил загвартай бөгөөд өсгий хэсгийг шөрмөсөн утсаар ил оёсон. Гутлын зулаг хэсгийг хатууруулж давхар шир тавьж, өсгийний залгаастай бөхөлж оёсон байна. Гутал урт 27 см, өргөн 8,5 см хэмжээтэй. Түрий салж үрэгдсэн. Хос гутал хар өнгийн арьсан гадартай, хадгалалт сайтай хэдий ч мэрэгч амьтад урж гэмтээсэн. Харин үстэй доторгүй нимгэн байгаа нь говь нутгийн дулааны улиралд урт хугацаанд өмсдөг гутал бололтой (Зураг 11).

Даавуун уут. Ногоон өнгийн даавуугаар хийсэн. Бүтэн биш. Нэг талын булан нь үжирч үрэгдсэн. Урт 33 см, өргөн 18,5 см хэмжээтэй.

Уутны ёроол болон дунд хэсэгт шар өнгийн утсаар цацаг хийж өгсөн.

Шарилд тавьсан дэвсгэр. Эсгий болон малын тарзыг давхарлан тавьсан. Эсгийг шарилд тавихаас өмнө дэвсгэр болгож ашиглаж байсан бололтой нэлээд хэдэн газарт зүйж, тэмээний ноосон утсаар хөвөрдөж оёсон. Эл дэвсгэрийг тонуулчид гаргаж хаясан учраас тодорхой хэлбэр хэмжээ мэдэгдэхгүй салбарч тамтаг төдий үлджээ. Мөн шарилын толгой болон цээжин дор, эсвэл сүүжин дор дэвсэж байсан бололтой нимгэн эсгийнд зэрэгцүүлэн зайгүй өрсөн зэгс маягийн бүдүүн дэрсийг эсгийгээр хучаад ноосон утсаар оёж бөхөлсөн ул мөртэй (Зураг 15). Уг дэрсэн дэвсгэрийн хэмжээ 44 x 40 см байна.

Хонины зүлд. Хонины бүтэн толгойн яс, 3 шийр, 3 хавирганы яс, 1 сээрийн яс гарсан. Толгой болон шийрийн яснууд арьстайгаа хатсан (Зураг 16в).



Зураг 8. Арьсан дээлийн үлдэгдэл



Зураг 9. Бүсний төмөр тоног



Зураг 10. а. Бүсний үзүүрийн төмөр тоног, б. Бүснээс зүүдэг гох




Зураг 11. Арьсан хос гутлын үлдэгдэл



Зураг 12. Эмээлийн мод



Зураг 13. а. Сухайгаар хийсэн модон дөрөө, б. Даавуугаар өнгөлсөн модон эдлэл



Зураг 14. а. Модон нумын хугархай, б. Навчин хэлбэрийн төмөр зэв, в. Сумны мөсний хугархай



а



б

Зураг 15. а. Талийгаачийн дор дэвссэн дэвсгэрийн хэсэг,
б. Дэвсгэрт бүдүүн дэрсийг эгнүүлэн эсгийд барьж оёсон нь

Палеоантропологийн судалгаа

Шар булгийн амны хадны оршуулгаас илэрсэн хүний яс нь харьцангуй бүрэн. Гавал доод эрүүний хамт, багана нуруу, урт мөчдийн яс бүрэн үлдсэн, баруун талын 9, зүүн талын 11 хавирга, зүүн хөлийн сүүж болон дунд чөмөг яс анатомийн байдлаараа, арьс нь бүрэн задраагүй хатаж үлдсэн бол хүзүү, сээр нуруу, бүсэлхийн нугалам мөн анатомийн байрлалдаа үргэлж хэвээр хадгалагдан үлджээ (Зураг 16а). Гавал ясны хүзүүний хэсэг байхгүй, аарцаг болон нарийн савхан ясны байдлаас үзэхэд эмэгтэй хүн ба доод эрүүний шүд амьд ахуйд нь унаж шүдний таславч битүүрч

эдгэсэн байгаагаас үзэхэд 70 болон түүнээс дээш настай хүн байжээ (Эрдэнэ 2020, 46). Харин Авдрант хайрхны хадны оршуулгаас гавал яс илрээгүй, доод эрүү, хос эгэм дал, баруун 10, зүүн 8 хавирга, хос сүүж ууцны хамт, хүзүүний 2, сээр нурууны 8, бүсэлхийн 5 нугалам, зүүн тойг, өсгий, гар хөлийн үений жижиг яснууд, урт мөчдийн ясны хамт илэрсэн (Зураг 16б). Бүтэн үлдсэн эрүүний яс болон сүүжний өнцөг хурц, булчин бэхлэгдэх гадаргуу хөгжсөн зэргээс үзэхэд эрэгтэй хүн ба эрүүний баруун талд үлдсэн араа шүдний илэгдсэн байдлаас харахад 45-50 настай байжээ. Шууд танигдах болон ил харагдах ясны



а



б



в



г

Зураг 16. а. Шар булгийн амны оршуулгаас илэрсэн хүний яс, б. Авдрант хайрхны оршуулгаас илэрсэн хүний яс,
в. Авдрант хайрхны оршуулгаас илэрсэн хонины яс буюу зүлд, г. Шар булгийн амны оршуулгаас илэрсэн хонины яс буюу зүлд

өвчлөл эмгэггүй. Зүүн талын урт мөчдийн ясны уртыг хэмжин бодож үзэхэд 170,1 см өндөртэй байжээ (Эрдэнэ 2021, 28).

Холбогдох он цаг

Энэхүү хадны 2 оршуулгын хүний яснаас дээж авч АНУ-ын Мичиганы Их Сургуулийн “Ancient Protein and Isotope” лабораторид илгээж

¹⁴C-ийн шинжилгээ хийлгэхэд үнэмлэхүй он цагийг дараах байдлаар нарийвчлан тогтоолоо. Тухайлбал, Шар булгийн амны оршуулга НТ 1503-1598 он буюу дундаж магадлалаар 1558 он, Авдрант хайрхны оршуулга НТ 1471-1634 он буюу дундаж магадлалаар 1564 онд холбогдох үр дүн тогтоогдлоо.

Shar bulag 73326 collagen Radiocarbon Age BP 310 +/- 20 Calibration data set: intcal20.14c # Reimer et al. 2020 % area enclosed cal AD age ranges relative area under probability distribution				Avdrant khairkhan 73327 collagen Radiocarbon Age BP 350 +/- 20 Calibration data set: intcal20.14c # Reimer et al. 2020 % area enclosed cal AD age ranges relative area under probability distribution 68.3 (1			
68.3 (1 sigma)	cal AD	1522 – 1575	0.823	sigma)	cal AD	1487 – 1522	0.434
		1624 – 1639	0.177			1576 – 1622	0.566
95.4 (2 sigma)	cal AD	1503 – 1598	0.786	95.4 (2 sigma)	cal AD	1471 – 1528	0.415
		1617 – 1645	0.214			1541 – 1545	0.006
						1550 – 1634	0.579
Median Probability: 1558				Median Probability: 1564			

Хэлэлцүүлэг

Өгүүлэн буй хоёр дурсгалын холбогдох он цаг нь Монголд шарын шашин дэлгэрч байсан цаг хугацаатай давхцаж байгаагаараа онцлогтой. Энэ түүхэн цаг үед монголчуудын уламжлалт оршуулгын зан үйлд өөрчлөлт гарсан юм. Монголд шарын шашныг хөгжүүлэх үндсийг Түмэдийн Алтан хан (1507-1582) тавьсан бөгөөд тэрбээр 1576 онд Төвөдийн шашны тэргүүн Содномжамц (1543-1588)-ыг хүндэтгэн залж, Монголд ирүүлээд өөрөө тэргүүлэн Ордосын бусад ноёдыг дагуулан шарын шашинд орж, Содномжамц хутагтыг бүх шарын шашны толгойлогч гэж өргөмжилж, “Далай лам” гэдэг цолыг түүнд өргөжээ. Үүний хариуд Содномжамц Алтан ханд Хубилай хааны бүх цолыг зүүхийг зөвшөөрчээ. Түүний дараа Анхдугаар Богд Өндөр гэгээн Занабазар гол төлөөлөгч болон тодорсон. Алтан хан эхлэн олон шинэ зарлиг цаазыг хуульчлан тогтоосны дотор “урьд Монгол улс хүн үхвээс, чинээ чинээгээрээ тэмээ, морийг алж, хойлго хэмээн хамт булах бүлгээ. Эдүгээ түүнийг тэвчиж чинээ чинээгээрээ номын зүгт зорьтугай” хэмээн (Саган сэцэн 2006, 151) эртний монголчуудын уламжлалт оршуулгын зан үйлийг цаазлан хоригложээ. Түүнчлэн монгол угсаатны язгуурын шүтлэг бишрэлийг хүчээр халж өөрчилсөн түүхэн үйл явдлын тухай III Далай лам Содномжамцын намтарт “урьд Цахар тэнгэрийн язгуураас гарсан хүч ихтэй, Хятад, Төвд, Монгол гурвыг хүчээр эрхэндээ хураасан бөгөөд сажийн лам нартай Тахилын орон, Өглөгийн эзэн бололцож шашныг дэлгэрүүлэв. Хойно Төмөр хаанаас эхлэн шашин цөлийдөж үйл үйлдэвч нүгэл хийж, идээн идэвч мах цус эдлэн хав харанхуй цусан далайн тив мэт болов. Тахилын орон, Өглөгийн эзэн хоёр нар, сар шиг

учирсны ачаар дээдийн шашны мөр нээгдэж цусан далайг сүүн далай болгон хувиргасны ач нь их учир энэ орон үг дэх Хятад, Төвөд, Хор Монгол тэргүүтэн хотлоор ч арван буяны цаазад орших хэрэгтэй. Энэ өдрөөс эхлэн ялангуяа Монгол, Цахарт цааз тогтоох нь: урьд Монгол улс үхэгсдийнхээ хойноос чинээ чинээгээрээ өөрийн эхнэр зарц боол, морь мал тэргүүтнийг алж байв. Үүнээс хойш алах орон болсон морь мал тэргүүтнийг дор дорын санаагаар хувраг, лам нарт өргөгтүн. Зориулга, ерөөл айлтга. Үхэгсдийн хойдоход зориулж амийг бүү тасал. Хэрэв урьдын адил хүн албаас цаазаар амийг нь цээрлүүлэхтүн. Хэрэв морь малыг албаас цаазаар бүх хөрөнгийг нь хураахтун. Лам тэргүүтэн хуврагийн ёстонд зодох жанчих зэргээр гар хүрвээс гар хүрсэн хүний гар тэргүүтэн мөчийг нь таслахтун. Урьд үхэгсдийн дүрсээр үйлдсэн онгод хэмээгчдэд нэр өгснөөр тохиолдуулан сар бүрийн битүүн, арван таван, найманд гурван удаа морь мал алж цусаар нь тахил үйлдэх зэргээр жил сарын тахилд чинээ чинээгээрээ их бага хэмжээгээр тоолшгүй олон амьтныг алдаг байсан хүмүүс өдгөөгөөс эхлэн тэдгээр шүтээнүүдээ галд шатааж жил сарын тахилд амь таслахыг хэзээ ч бүү үйлд. Хэрэв чингэвээс цаазаар гэсгээн алсан морь малын тоогоор нь арав нугалж торгогтун. Онгодыг галд үл шатааваас голомтыг нь сүйтгэ. Онгодын оронд оюун билгийн итгэл зургаан Мутартны дүрийг шүтэж, түүнд гурван цагаан тахилаас өөр мах цусан тахилыг хэрхэвч бүү үйлд. Бас бүгдээр буяныг шамдан битүүн, арван таван, найман гуравт мацаг сахигтун” хэмээн цааз гаргажээ (Бира 1970, 14-15).

XVI зууны үед холбогдох хятад сурвалж бичиг буюу Мин улсын элч Сяо Дахэн хэмээх нэгэн хятад хүн 1594 онд бичсэн “Умардын бүдүүлгүүдийн зан

суртахууны тэмдэглэл” бичигт “Монголчууд угаас өвчилбөөс эм дом уудаггүй. Ойрд тангараглан дагаж алба барих болсноос нааш өвчин эмгэгийг нь анагаан, эрүүл тэнхлүүн болгохын тул удаа бүр эм шагнасан боловч олонхдоо тус гарсангүй шалтгааныг нь бодвол, монгол хүн балмад бүдүүлэг чанартай бөгөөд идээ ундаа, хувцас хунар нь ч дундад орныхтой адилгүй тул хий суудал нь түргэдээд, гадар нь сүрлэг боловч дотроо буурай байдаг. Ямагт нас залуугаараа нөгчдөг. Өндөр настай хүмүүс их цөөхөн. Тэдний оршуулан онголохын ёс нь нэн сонирхолтой. Угтаа монголын хаад ба тайж нар үхвэл бас нэг зэрэг авс модыг бэлтгэн, үхэгсдийн эдэлж асан хувцас хунар, хуяг дуулга зэрэг зүйлтэй нь хамт өвс модоор сахлаг бөглүү хол газарт оршуулна. Үхсэн өдөрт нь Чиньмү гүнгийн хойлго оршуулгын санаа зорилготойгоор үхэгсдийн хайртай боол шивэгчин, татвар эхнэр, сайн морьдыг алаад хойлгод гаргадаг байжээ. Хүүр онгонд булсан хувцас хуяг ба хүүрийн гаднах морины мах жич өвс модыг хулгайлагсдыг баривчилмагц алах бөгөөд үр хүүхдийг нь боолчлон, хөрөнгө хогшлыг нь хураан авна. Эгэл ардын хүүр хулгайлсныг бас ч есөн есөөр ялдана. Үүнээс сэргийлэхийн тулд ер нь бусад газарт майхнаар харуул гаргаж, энд ямар ван, ямар тайжийн онгон буй гэж худал үг яриа талбих нь Цаоцаогийн хэрэглэсэн ухааныг дуурайсан юм биш үү. Монголын ёсонд гурван жил бэлэврэл хийдэггүй. Зөвхөн долоо хоногийн дотор эхнэр хүүхдээс нь эхлэн харьяат ард нь гу гу малгайн жинсээ зүүхгүй. Долоон хоног өнгөрмөгц малгайн жинсээ авч зүүдэг байна. Эдүгээ хичээнгүйлэн алба үзэж, бурхан шашныг маш их сүслэн биширснээс бусад зүйлийн заншил нь хэдийгээр хэвээрээ байдаг боловч ганц хүүр оршуулахад амьтны амийг нядлах гэмтэй явдал нь нэлээд өөрчлөгдсөн байна. Лам гэдэг баруун орны хуушаанууд гал оршуулгын аргыг зааж өгснөөр үхэгсдийг галд түлээд ясыг нь талхдаж шавартай нийлүүлэн шуумал хөрөг болгоод түүнийгээ алтдах буюу мөнгөлөөд сүм хийдэд авчирч тавина. Ойрын жилүүдээр сүм хийдийг их л байгуулсан тул лам залаад дөчин есөн өдрийн ном уншуулна. Эгэл ард гэсэн ч лам залаад долоон өдрийн ном уншуулдаг болжээ. Үхэгсдийн хайртай сайн хүлэг, хувцас болон хуягийг нь ламд өргөл болгож өргөнө. Харьяат олон ард нь талийгаачийн хойноос буян хийхээр морь мал авч зүг бүрээс ирнэ, үүнийг ч ламд өргөл болгон барина. Үхэгсдийн хойлгод орсон хүн бүхнийг алахгүй болгосон. Гэвч төрсөн эхээсээ бусдыг хөвгүүн нь хураамжлан авах ба хүү нь үхвэл эцэг нь хуяглаж зэвсэглээд үүдэн эсрэг нь гурвантаа цавчилсхийгээд, мөнхүү бэрээ хураамжлан авах энэхүү самуун заншлыг нь бурхан шашин ч

өөрчилж чадсангүй. Тэрхүү шавар хөрөг нь өнө удаан уламжлагдсаар байвч уг хэвээр нь тахиж шүтээд, айгаад эвдэхгүй юм. Бодож үзвэл, хөрөг зургийн шашин шүтээн нь өрнөд орноос үүсэж, умард оронд дэлгэрээд чийрэг догшныг өршөөл энэрэнгүйд улайруулав. Үүнийг вангийн ёсон гэсгэхэд өчүүхэн төдий тус нэмэр болов гэж яахан хэлж болох аж” хэмээн өгүүлжээ (Сяо Дахэн 2022, 49).

XVIII-XIX зууны монгол сурвалж бичигт монголчуудын оршуулгын зан үйлд гарсан өөрчлөлтийн талаар цөөнгүй дурдагддаг. Тодруулбал, “Болор толь”-д “урьд монгол хүн үхвээс өөрийн морийг эмээл хазаартай нь хүүрийн дэргэд уях буюу алдаг. Түүнээ тэвчиж лам хуврагт өргөж ерөөл ав. Хэрвээ урьдын мэт морь үхрийг алах бөгөөс цаазаар эд мал бүгдийг яллан авах, лам хувраг дүртэй хүнийг гөвших ба гар хүрвээс тэр хүнийг хүндэд ялламуу. Урьд онгон хэмээн эцэг өвгийн дүрсийг хийж сар бүрийн шинийн найман, арван таван, гучин энэ гурван өдөрт амьтан алж мах цусаар тахидаг, түүнээ нэгмөсөн тэвчээд, тэр онгодын шүтээнийг шатаа хэмээвэй. Хэрвээ онгодыг тахиж мал албаас, тэр малын зэрэг тоогоор арав ялламуу. Онгодыг тахиыхын оронд номын сахиус Гомбыг шүтэж сар сар гурван дүйчин өдөр бацгийн санваар авсугай. Энэ мэтийн хууль тогтоосныг сайтар хянаж бодон санаж явагтун” гэж дурджээ (Жамбалдорж 2006, 343). Мөн Эрдэнийн товчид “урьд эцэг нь Алаг жононгийн гурван гэргийн гутгаар нь, Молан хатан хэмээхүйг, эцэг юүгээн тэнгэр болсны хойно, Алтан хаан авсан ажгуу. Түүнээс Төвөд тайж хэмээх гагц хөвгүүн буюу. Тэр хөвгүүн нь үгүй болсонд хатан эх нь хилэнцээс үл айхын тул, зуун хүний хүүхнийг алж дагуулах, зуун ингэний ботгыг алж буйлуулах хэмээн дөчин илүү хүүхдийг алуулан бүхийеэ, их улс эвдрэл болон завдахуйд, Монголжины Шинихэй өрлөгийн хөвгүүн Жугандулай хиа тайж хэмээх, бус хүний хүүхдийг тэр газраа хүүхнийг зовоох, би одсу. Намайг алж дагуул хэмээсэнд, түүнийг алж үл болохын тул огоорч, түүнээс хойдыг нь алахуйгаа огоорчээ” хэмээн өгүүлжээ (Саган сэцэн 2006, 159).

Дурдсан сурвалжийн мэдээг археологийн хэрэглэгдэхүүнтэй холбогдуулан авч үзэх нь чухал бөгөөд Монголын үеийн булш оршуулгын дурсгалыг судлаачид I. Эртний Монголын үе X-XII зуун, II. Сонгодог үе XIII-XIV зуун, III. Хожуу үе XV-XVII зуун хэмээх үечлэл авч үздэг (Erdenebat 2009, 103) ба Ханангийн бууцны 1-р булш (Эрдэнэбат 2010, 339), Хатны булагийн Зүүн шивээний Б-3 булш (Өлзийбаяр нар 2018, 149) мэдэгдэж байсны дараагаар 2024 оны байдлаар хожуу үе буюу XV-XVII зуунд холбогдох Тэмээн чулууны хөтлийн 2-р булш 340±20, Чандмань

Хар уулын 215-р булш 392±49, 75-р булш 422±43, Зэлтийн голын 1-р булш 433±458 онд гэх мэт хэмээн хожуу үеийн ангилалд цөөнгүй булш холбогдож байгааг нэмж тогтоожээ (Батдалай 2024, 168). Харин хадны оршуулгын хэлбэрээс хожуу үед хамаарах нь судалгааны тоймоос үзэхэд радиокарбоны шинжилгээгээр тогтоогдсон нь хамаагүй цөөн тоотой байдаг. Тухайлбал, Говь-Алтай аймгийн Халиун сумын нутаг Авст, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутаг Хүйтэн хошуу, Ховд аймгийн Алтай сумын нутаг Хөтөл өтөг, Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын нутаг Хөндлөнгийн хадны оршуулгууд юм. Эдгээр нь Шар булгийн оршуулгын адил Алтайн нуруунаас ойролцоо бүс нутгаас илэрсэн бөгөөд холбогдуулан товч байдлаар дурдах нь зүйтэй.

Австын хадны оршуулгаас ихээхэн сонирхолтой “сараалжин” авс илэрсэн бөгөөд модон шургаагийг шат мэт шаантаглан холбосон ба авсны доод хэсэгт шал болгон бургасны мөчрийг уртааш нь битүү дэвсэж байжээ. Авсны ёроол хадгалагдан үлдсэн хэсэгт хүний аарцаг, багана нурууны яснууд хамт хөндөгдөөгүй байдалтайгаар илэрчээ. Хадны завсрын доторх зай, авснаас үлдсэн хэсгүүдийн байрлалаас үзвэл оршуулга зүүн урагш ханджээ. Эндээс илэрсэн хүний яснаас дээж авч ^{14}C -ийн шинжилгээнд хамруулахад 95%-ийн магадлалаар 1430-1620 он, 50%-ийн магадлалаар 1460-1560 оны хооронд холбогдох он цаг гарчээ (Батболд 2022, 258).

1986 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын Хүйтэн хошуу хэмээх газарт нэгэн хадны оршуулга малтан шинжилжээ. Хадтай толгойн өмнөд үзүүрт буй хадан ангалын дотор 50 орчим насны эрэгтэй хүнийг толгойг нь дорно зүг хандуулан оршуулсан байжээ. Авсны оронд их биеийг гэрийн ханаар ороож тэнэгэр байдлаар тавьсан ба доор нь ясан хяртай модон эмээл хөндлөн тавьжээ. Оршуулгаас гарсан гэрийн ханын модноос ^{14}C -ийн он цаг тогтоох шинжилгээний дээж авч хийлгэхэд 320 BP±700 1400-1850 cal AD”-д холбогдох үр дүн гарчээ (Эрдэнэбат 2022, 262).

Ховд аймгийн Алтай сумын нутаг Хөтөл Өтөг хэмээх газар айлын өвөлжөөний арын улаан боржин хадтай уулын урд талын аманд зүүн хойш харсан хадны хөмөгт чулуугаар дарсан оршуулга олджээ. Тус хөмөгт хүнээ оршуулахдаа эсгий, түүн дээрээ ямааны арьс, хар хурганы арьс зүүж дээрх 3 эдлэлийг давхарлан дэвсэж ороосон бололтой байжээ. Эндээс эмээлийн мод, даавууны тасархай, модон эдийн хугархай илэрчээ (Төрбат нар 2008, 284). Судлаачид оршуулгын холбогдох он цагийг тодорхойлох үүднээс ^{14}C -ийн он цаг тогтоох дээжийг шинжилгээнд хамруулж үзэхэд 260±30 1620-1760 cal AD”-д холбогдох үр дүн гарчээ (Ahrens et al 2015, 107).

Хөндлөнгийн хадны оршуулга нь цуурч унасан хоёр том хадны голын завсрыг ашиглан оршуулга үйлдээд чулуугаар дарсан ажээ. Судлаачдыг малтаж үзэхэд толгойг зүүн хажуугаар, зүүн гарыг бүтэн нугалж сарвууг нүүрэн тушаа, баруун гарыг хэвлий дээгүүр дамнуулан, хоёр хөлийг өвдгөөр хагас нугалан зүүн талруу нь жишүү маягтай тавьжээ. Энэхүү оршуулгаас илэрсэн хүний гавлын ясны заадас сайн мэдэгдэх ба дух, хөмсөгний яс, аарцагны яс, дунд чөмөгний яс зэрэг хэсэгт тулгуурлан талийгаачийг 178,7 см өндөртэй, 35-45 насны эрэгтэй хүн болохыг тодорхойлсон ба хүний яснаас дээж авч ^{14}C -ийн шинжилгээнд хамруулахад 1710-1810 оны (50%) хооронд хамаарах боломжтойг тогтоожээ (Батболд 2022, 266).

Бидний өгүүлэн буй хоёр оршуулга нь холбогдох он цагийнхаа хувьд адил XVI зууны дунд үед хамаарах бөгөөд Монголын түүхийн судалгаа харьцангуй багатай хэмээн үздэг байсан “Бутралын үе” буюу XVI-XVII зууны үеийн эгэл жирийн хүний оршуулгын соёлын нэгээхэн төлөөлөл болох юм. Тиймээс олдсон бүс нутгийн онцлогийг товч боловч тодруулах үүднээс монгол орны Алтай нурууны болон Говийн бүс нутгийн байдлаар нь харьцуулан авч үзэх боломжтой хэмээн үзэв. Ингэж авч үзэхдээ оршуулгын зан үйлийн зарим элемент, эд өлгийн зүйлсэд нь тулгуурлав. Үүнд:

- Хувцас өмсгөл ба гутал
- Агт морины хэрэгсэл
- Ахуйн эд хэрэглэл
- Оршуулгын эд хэрэглэл
- Хойлгын ёс зэргээр нь адил болоод ялгаатай байдлыг тодорхойлов.

Хоёр оршуулгаас хувцас өмсгөлийн зүйл бүрэн бүтэн байдлаар нэг ч олдвор илрээгүй хэдий ч Шар булгаас гарсан арьсан өмдний үлдэгдэл, Авдрант хайрхны оршуулгаас гарсан арьсан дээлийн ханцуйны үлдэгдэл (Зураг 8) ба төмөр тоноглолтой суран бүс бий (Зураг 9-10). Харин хоёр оршуулгаас тус тусдаа арьсан хос гутал илэрсэн (Зураг 5в, 11). Гутлууд эсгүүр, оёдол хийцийн хувьд яг адил ч хэв загвараар Авдрант хайрхны оршуулгын гутал хоншоор хэсэг ээтэндүү, ул болоод их биеийн арьс нимгэн байгаа нь илэрхий мэдэгдэнэ. Гутлын тухайд сурвалж бичигт “эмэгтэйчүүд нь эрэгтэйчүүдтэй адил гутал өмсдөг. Гутлын ул нь маш нимгэн, морь унахад дөхөм ажээ” хэмээн тэмдэглэсэн байна (Сяо Дахэн 2022, 55). Агт морины эмээлийн хэлбэрээс үзэхэд Алтай нутгаас илэрсэн нь урд бүүрэг дөрвөлжин хэлбэртэй, гуулин хяртай, төмөр тоноглолтой (Зураг 3). Говийн бүсийн эмээлийн урд бүүрэг шовгор босоо, гадна талыг улаавтар өнгийн будгаар шунхадсан онцлогтой (Зураг 12). Дөрөөний хувьд говь нутагт түгээмэл ургадаг сухай модоор (Зураг 13а) өвөрмөц хэлбэртэй хийсэн бол Шар

булгийн амны оршуулгаас хоёр өөр хэлбэртэй модон дөрөө илэрсэн (Зураг 4б). Модон дөрөө материал болоод хийц хэлбэрийн хувьд бүс нутгийн ялгаатай байдлыг тодруулж байна. Ахуйн эд хэрэглэл нь суулгын модон таг, сам, даавуун уут зэрэг зүйлсээрээ нийтлэг байгаа ба зэр зэвсгийн хувьд зөвхөн Авдрант хайрхны эрэгтэй хүний оршуулгаас нум сум, төмөр зэв илэрсэн юм.

Оршуулгын зан үйлд ашигласан зүйлс нь уламжлалт байдлыг хадгалсан байх бөгөөд хадны оршуулгын хувьд гэрийн хана юм уу ачлага мод нь оршуулгын зан үйлтэй нягт холбогдохоос гадна хэрэглээнийхээ хувьд талийгаачийг хол газарт морь малд тээвэрлэн өгсүүр бартаа саадтай замаар авч явахад маш тохиромжтой хөнгөн авсаархан байх ба зарим тохиолдолд оршуулгад авс болгон ашигладаг байдал Шар булгийн амны оршуулгад (Зураг 6) тодорхой харагдана. Ийм тохиолдол Хүйтэн хошуу (Мэнэс 2020, 81), Дараатай шовгор (Хүрэлсүх нар 2020, 103), Оюут овоогийн 29-р булш (Мөнхтулга нар 2021, 43), Цогт уулын 4-р булшинд (Батболд нар 2024, 226) мэдэгддэг. Авдрант хайрхны оршуулга авсгүй бөгөөд гарсан эд зүйлсээс үзэхэд шарилыг эсгийд ороосон ба дор нь зэгс маягийн бүдүүн дэрс зэрэгцүүлэн эгнүүлж эсгийд барьж тэмээний ноосон утсаар оёсон дэвсгэрийн (Зураг 15) үлдэгдэл гарсан. Энэ зүйлтэй адил хэрэгсэл өөр 4-5 оршуулгад тохиолддог. Харин Шар булагийн амны эмэгтэй хүний оршуулгад дундад зууны монголчуудын булшинд цөөнгүй тохиолддог нэгэн зан үйл болох талийгаачийн толгой дор дэр тавих ёсыг уламжлуулан хийжээ.

Шар булгийн амны оршуулгад талийгаачийг зүүн урагш буюу голынхоо болон хавцлынхаа эх рүү хандуулсан нь уламжлалт зүг чигийг эрхэмлэх зан үйлийг харгалзалгүй тухайн уулынхаа эх оргилыг чухалчлан зүглүүлжээ. Талийгаачийн гавлыг хөндсөн хэдий ч бусад яс хөндөгдөөгүй анхны тавилтаар илэрсэн ба толгойд нь модон сам (Зураг 5а), дөрөө (Зураг 4б), эмээл (Зураг 3) дэрлүүлсэн. Оршуулгаас адууны иж бүрэн тоног хэрэгсэл болох төмөр тоногтой эмээл (Зураг 3), хоёр өөр хэлбэрийн модон дөрөө (Зураг 4б), гархин зуузайтай төмөр амгайтай давхар суран хазаар (Зураг 4а), гуулин хяр илэрсэн ба арьсан гутал (Зураг 5в), модон сам (Зураг 5а), суулгын модон таглаа (Зураг 5б) зэргээс гадна оршуулгын дээр гэрийн хана, унь, ачлага модыг (Зураг 6) хучиж тавьсан байдлаар илэрсэн юм. Гэрийн хана, унь нь талийгаачийн нөгөө ертөнцөд амьдран суух гэрийг төлөөлүүлэн дагалдуулсан зүйлс хэмээн үзэж болох бөгөөд оршуулгын зан үйлийн чухал хэсэг буюу шарилыг тээвэрлэн авч явахад, заримдаа авсны үүргийг давхар гүйцэтгэдэг онцлогтой. Тухайлбал, Ховд аймгийн Булган

сумын харьяат Ж.Баяр 1987 оны 3 сарын 7-нд өгсөн аман мэдээнд торгуудууд нас барсан хүнийг “тэмээнд гэрийн тэрэм (хана) дэлгээд тэгнэдэг байсан” хэмээжээ (Жигмэддорж 2023, 117). Энэ нь саяхныг хүртэл эл уламжлал байсныг илтгэнэ.

Харин Авдрант хайрхан уулын хадны оршуулгыг тонуулчид ихэд сүйтгэсэн байсан нь оршуулгын зан үйл, анхны тавилт зэргийг тодорхойлох боломжгүй болгожээ. Уг хадны оршуулгаас хүний яс болон эмээл (Зураг 12), модон хос дөрөө (Зураг 13а), арьсан дээлийн үлдэгдэл (Зураг 8), суран бүсний төмөр тоног чимэглэлүүд (Зураг 9-10), арьсан хос гутал (Зураг 11), ясан наалттай нумын хугархай (Зураг 14а), навчин хэлбэрийн төмөр зэв (Зураг 14б), сумны мөс (Зураг 14в), нимгэн хавтгай ясан чимэглэл, шарил тавьсан дэвсгэрийн үлдэгдэл (Зураг 15), оршуулгад зүлдэж тавьсан хонины толгой, шийр, хавирганы яс (Зураг 16в) гарсан юм. Маш сайн хадгалалттай эмээл болон модон хос дөрөөг судлаачдыг очихоос өмнө хүн авч явсан байсныг сурвалжлан олж авсан ба суран бүсний төмөр тоног чимэглэл, арьсан хос гутал, модон хос эдлэл зэрэг нь судалгааны хувьд ихээхэн сонирхолтой хэрэглэгдэхүүнүүд юм.

Эртний хүн судлалын шинжилгээгээр Шар булгаас 70 гаруй насны эмэгтэй хүн (Зураг 16а), Авдрант хайрхны оршуулгаас 45-50 насны, 170,1 см өндөртэй эрэгтэй хүн (Зураг 16б) олдсон нь тогтоогдов. Дээрх хоёр оршуулгад хонины толгой, шийр бүхий зүлд тавьсан нь дундад зууны үеийн оршуулгын ёслолын нэгэн элемент болох хонины махан хойлгын зан үйлийн уламжлал “амь бөх”-тэй байсныг илтгэнэ. Дундад зууны монголчууд нас барсан хүмүүсийнхээ булш оршуулгад ийнхүү малын махны тодорхой хэсгийг сонгож дагуулан хойлголд байсан нь цаанаа ёслолын болон бэлгэдлийн утга агуулгатай болж, хойлгоны дотор хонины мах, тэр дундаа шагай чөмөг, толгой шийр монгол угсаатны бэлгэдэл зүйн сэтгэлгээн дэх үржлийн болон нөгөө ертөнц, сүнс эргэж төрөх тухай үзэл төсөөлөлтэй нягт холбогдож байжээ (Эрдэнэбат нар 2010, 76).

Дүгнэлт

Хүн төрөлхтний нэгэн адил Монголчуудын хувьд ч оршуулгын зан үйл, түүний хэлбэр нь түүхэн цаг хугацаанд уламжлагдах, хувьсах зэргээр тухайн цаг үеийнхээ нөхцөл, шаардлагаар өөрчлөлт шинэчлэлийн харилцаанд орж ирсэн бөгөөд энэ удаа малтан шинжилсэн дурсгалын хэрэглэгдэхүүнд тулгуурлан харьцангуй хожуу үед хамаарах өөрчлөлтийн тухайд товч авч үзлээ.

XVI зууны хожуу үе гэхэд нүүдлийн ахуйн соёлтой монголчуудын хувьд өвөг дээдсээс нь уламжилж, нэгэнт хэвшиж он удаан жил хэрэглэж

дадсан оршуулгын зан үйлийг нь сүсэг бишрэл, цааз зарлигаар “энэ өдрөөс эхлэн...” хэмээн нэн даруй хориглож байсан хэдий ч өргөн уудам нутагт айл саахалтаараа, уул усаа даган тархаж амьдардаг монголчуудын хувьд тийм амархан хувьсан өөрчлөгдөөд байх бололцоо, нөхцөл багатай байсан нь дамжиггүй. Үүнийг археологийн биет хэрэглэгдэхүүн, сурвалж бичиг, угсаатны зүйн мэдээ, элч жуулчдын тэмдэглэл зэргээс тодорхой харж болохоор байдаг ажээ.

Дундад зууны хожуу үед бурхны шашныг нийгмийн бүхий л давхаргын түвшинд хүлээн авсантай холбоотой монголчуудын оршуулах зан үйлд гарсан өөрчлөлт, үхэгсдийн хойноос мах цусан тахил өргөх заншлыг цаазлан хориглосон түүхэн үйл явдлыг тухайн үеийн монгол, төвөд, хятад сурвалжийн мэдээ, сүүлийн үеийн байгалийн шинжлэх ухааны аргаар холбогдох он цагийг яв цав тодорхойлсон археологийн дурсгал болох булш оршуулгад тулгуурлан тодорхойлох нь зүйтэй (Эрдэнэбат 2010, 347) хэмээн үзсэнтэй санал нэг байна.

Өнөөгийн судалгааны хүрээнд монголын үеийн хожуу үед хамаарах булшны холбогдох он цагийг лабораторийн шинжилгээгээр тогтоосон нь хангалтгүй байгаа бөгөөд хадны оршуулгын хэлбэрээс нь авч үзэхэд ердөө 6 оршуулга л тодорхой мэдэгдэх ба чулуун дараастай булшны байдлаас үзэхэд мөн 20-оод тооны булш л хамаарч байна. Энэ нь мэдээж сонгодог монгол булшны тоо хэмжээ, тархалт зэрэгтэй харьцуулахын аргагүй бөгөөд өмнөх судалгааны хүрээнд (эд өлгийн зүйлсийг харьцуулалтын аргаар) XIII-XIV зууны үе хэмээн авч үзсэн булшны тоонд хожуу үеийн булш холилдсон байх магадлал ихтэй. Учир нь хожуу үеийн аль ч хэлбэрийн булш нь сонгодог үеийн оршуулгын зан үйл, булшны байршил, хэлбэр хэмжээ, нүхний гүн, зүг чиг, дагалдуулсан эд өлөг, хойлго зэргээрээ ялгагдах юмгүй ижил байдаг. Тиймээс холбогдох он цагийг нь харьцуулалтын аргаар бус зөвхөн лабораторийн шинжилгээгээр тодорхойлж тогтоогдсон хойно л сая хожуу үеийн булш гэдгийг мэдэх боломжтой болдог. Энэ нь ч олон талын учир шалтгаантай бөгөөд одоо харин зааг ялгааг нь илүү тодорхой болгож, дүгнэх үүднээс XVI-XVIII зууны үеийн монголчуудын оршуулгын зан үйлийн мэдээллийн сан үүсгэж, нэлээд өргөн хүрээнд системтэйгээр авч үзэх шаардлагатай болж байна. Энд бидний хамаатуулан авч үзэж буй эл хоёр дурсгал нь XVI зууны үе буюу хожуу үеийн эгэл жирийн монголчуудын ахуй, соёлыг судлан шинжлэх, нэхэн сэргээн ойлгоход хувь нэмэртэй хэрэглэгдэхүүн болох юм.

Эцэст нь тэмдэглэхэд өгүүллийн үндсэн хэрэглэгдэхүүнд аль болох лабораторийн аргаар

он цагийг нь тогтоосон булшийг хамруулсан бөгөөд шарын шашин Монголд III удаагаа дэлгэрэхдээ монголчуудын оршуулгын зан үйлд гүнзгий нөлөө үзүүлж “ил тавих” хэлбэр олонхын дэмжлэг хүлээн, өргөн хүрээнд тархсан хэдий ч талийгаачийг газарт булшлах, агуй, хаданд далд тавих хэлбэр цөөн гэлтгүй хадгалагдсаар тун саяхныг хүртэл буюу XVIII-XIX зууныг хүртэл уламжлалт ёсны ул мөр болон үргэлжилж байснаас үзэхэд уламжлал, шинэчлэл хоёр ямагт хослон оршдог ажээ.

Талархал

Шар булгийн амны дурсгалын судалгааны ажлыг дэмжиж, хамтран ажилласан Ховд аймгийн Музейн эрдэм шинжилгээний ажилтан Х.Бямбасүрэн, тус аймгийн Дуут сумын Соёлын төвийн ажилтан Х.Баярсайхан, Авдрант хайрхны дурсгалыг судлан шинжлэхэд газарчлан зааж өгсөн Улаанбаатар хотын харьяат Д.Жанчив, Өмнөговь аймгийн Номгон сумын Соёлын төвийн ажилтан Н.Урантогос, олдворыг хамгаалан хадгалж байсан нутгийн малчин Б.Отгонбаяр, дээж шинжилж өгсөн АНУ-ын Мичиганы Их Сургуулийн “Ancient Protein and Isotope” лабораторийн эрхлэгч, доктор (Ph.D) дэд профессор Алиша Вентреска Миллер нартаа гүн талархал илэрхийлье.

НОМ ЗҮЙ

Батболд Н. Австын дурсгал. “Монголын Археологийн өв” цувралын XIII боть “Монголын хадны оршуулгын дурсгал” эрдэм шинжилгээний каталог. Улаанбаатар, 2022. тал 258-259.

Батболд Н. Хөндлөнгийн дурсгал. “Монголын Археологийн өв” цувралын XIII боть “Монголын хадны оршуулгын дурсгал” эрдэм шинжилгээний каталог. Улаанбаатар, 2022. тал 266-267.

Батболд Н, Түвшинжаргал Т, Амарболд Э. “Монголын эзэнт гүрний археологи” төслийн хүрээнд Сэлэнгэ аймагт хийсэн монгол булшны малтлага судалгаа. // “Монголын археологи-2024” эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2024. тал 225-228.

Батдалай Б. X-XVII зууны монгол булш, оршуулгын судалгаа (Монгол улсад малтсан хэрэглэгдэхүүнээр). Түүхийн ухааны доктор (Ph.D)-ын зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, 2024.

Бира Ш. Хутагтай сэцэн хун тайжийн зохиосон нэгэн хуулийн тухай. // *ШУАМ*, №3. Улаанбаатар, 1970. тал 14-21. <https://doi.org/10.1017/S1356186304003530>

Жамбалдорж. Болор толь (дэд дэвтэр). Монгол бичгээс хөрвүүлж, оршил бичиж, тайлбар хийсэн С.Цолмон, Д.Бүдсүрэн, Д.Нямаа, С.Амарбаяр, П.Бямбахорол. // *Монголын түүхэн сурвалж*

бичгийн цуврал. Боть 22. Улаанбаатар, 2006.

Жигмэддорж Э. XVI-XVII зууны монголчуудын оршуулгын зан үйлийн зарим өөрчлөлт. Монголчуудын хойлгын зан үйл: Уламжлал-орчин үе-чиг хандлага IV. Эрдэм шинжилгээний гуравдугаар хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2023. тал 100-127.

Мөнхтулга Р, Хүрэлсүх С, Батбаяр Т, Бадма-Оюу Б, Мандах Д. Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутаг Оюут овоо дахь “Голден погада” ХХК-ийн ашиглалтын хэсэгт гүйцэтгэсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2011. АХГБСХ.

Мэнэс Г. Хүйтэн хошууны хадны оршуулга. Монголчуудын гарал, угсаатны түүх: “Палеоэтнографийн экспедици”-ийн хээрийн шинжилгээний эх хэрэглэгдэхүүн (1986-1989). Улаанбаатар, 2020. тал 76-85.

Өлзийбаяр С, Баатархүү Б. XIV-XVII зууны монголчуудын оршуулгын зан үйлийн асуудалд (Хатны булгийн оршуулгын жишээгээр). Монголчуудын хойлгын зан үйл: Уламжлал-орчин үе-чиг хандлага. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар, 2018. тал 137-154.

Саган Сэцэн. Эрдэнийн товч. Сонгомол эх бэлтгэж хөрвүүлэг, тайлбар зүүлт хийсэн М.Баярсайхан. // Монголын түүхэн сурвалж бичгийн цуврал. Боть 8. Улаанбаатар, 2006.

Сяо Дахэн. Монголын зан суртахууны тэмдэглэл. (Редактор Д.Идэр). Монголын дунд үеийн түүхэнд холбогдох хятад сурвалж бичиг. Улаанбаатар, 2022, тал 42-129.

Төрбат Ц, Батсүх Д, Батбаяр Т, Баярхүү Н, Идэрхангай Т. Монгол Алтайгаас илэрсэн хадны оршуулгууд. *Studia Archaeologica. Tomus (VI) XXVI, fasc. 14*. Улаанбаатар, 2008. тал 274-292.

Хүрэлсүх С, Цао Жиан Эн, Сүн Гүо Дүн, Бямбасүрэн Х, Баярсайхан Х, Цао Пэн, Цай Си. Дараатай Шовгорын хадны оршуулга. The Ulaanbaatar State University Mongolia. “*Journal of the Archaeology, History and Humanitarian*”. (Volume 16 (15), fasc 8. Улаанбаатар, 2020. тал 96-103.

Хүрэлсүх С, Энхтөр А. Ховд аймгийн Дуут сумын нутагт явуулсан археологийн авран хамгаалах судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2020. АХГБСХ.

Хүрэлсүх С, Энхтөр А. Шар Булагийн амны дурсгал. “Монголын Археологийн өв” цувралын XIII боть “Монголын хадны оршуулгын дурсгал” эрдэм шинжилгээний каталог. Улаанбаатар, 2022. тал 233-241.

Хүрэлсүх С., Уртнасан Э. Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт явуулсан археологийн авран хамгаалах судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2021. АХГБСХ.

Хүрэлсүх С, Уртнасан Э. Авдрант хайрханы

дурсгал. “Монголын Археологийн өв” цувралын XIII боть “Монголын хадны оршуулгын дурсгал” эрдэм шинжилгээний каталог. Улаанбаатар, 2022. тал 244-251.

Эрдэнэ Б. Ховд аймгийн Дуут сумын нутгаас илэрсэн хүний ясанд хийсэн палеоантропологийн судалгаа. Ховд аймгийн Дуут сумын нутагт явуулсан археологийн авран хамгаалах судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2020. тал 44-47. АХГБСХ.

Эрдэнэ Б. Палеоантропологийн тодорхойлолт: Авдрант хайрхны хадны оршуулгаас илэрсэн хүний ясны олдвор. Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт явуулсан археологийн авран хамгаалах судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2021. тал 28. АХГБСХ.

Эрдэнэбат У. Хүйтэн хошууны дурсгал. “Монголын Археологийн өв” цувралын XIII боть “Монголын хадны оршуулгын дурсгал” эрдэм шинжилгээний каталог. УБ., 2022. тал 262-263.

Эрдэнэбат У, Амартүвшин Ч. Дугуй Цахирын хадны оршуулга (X-XII зуун). Улаанбаатар, 2010.

Эрдэнэбат У. Монгол булшны судалгаа. Дундговь аймагт хийсэн археологийн судалгаа: Бага газрын чулуу. Улаанбаатар, 2010. тал 313-378.

Ahrens Birte, Nomguunsüren Gončigsüren, Piezonka Henny, Holger Becker, Regina Klee, Michelle Machicek, Bruno Frohlich und Tsend Amgalantugs. Das mittelalterliche Höhlengrab von Cagaan Chad, Mongolei. Eine Kriegerbestattung am nördlichen Rand der Wüste Gobi. *Zeitschrift für Archäologie des Mittelalters*. Bonn, 2015. pp 59-126

Erdenebat Ulambayar. Altmongolisches Grabbrauchtum - Archäologisch-historische Untersuchungen zu den mongolischen Grabfunden des 11. bis 17. Jahrhunderts in der Mongolei. Dissertation, Rheinische Friedrich-Wilhelms-Universität Bonn (Online-Publikation Bonn 2009: <http://hss.ulb.uni-bonn.de/2009/1958/1958.htm>).

REFERENCES

Batbold N. Avstiin dursгал. *Archaeological Relics of Mongolia catalogue series. Rock burials of Mongolia. 13 volume*. Ulaanbaatar, 2022. pp 258-259.

Batbold N. Khündlüngein dursгал. *Archaeological Relics of Mongolia catalogue series. Rock burials of Mongolia. 13 volume*. Ulaanbaatar, 2022. pp 266-267.

Batbold N, Tuvshinjargal T, Amarbold E. “Mongoliin ezent gürnii archaeology” түслийн khureend Selenge aimagt khiisen mongol bulshny maltлага судалгаа. // “*Mongolyn archaeology-2024*” erdem shinjilgeenii khurliin emkhetgel. Ulaanbaatar, 2024. pp 225-228.

Batdalai B. X-XVII zuunii mongol bulsh, orshuulgein судалгаа (Mongol ulsad maltsan

khereglegdekhüüneer). Түүхийн ухааны докторийн (Ph.D)-ийн зэрэг горилсон бүтээл. Улаанбаатар, 2024.

Bira Sh. Khutagtai setsen khun taijiin
zokhioson negen khuuliin tukhai. // *SHUAM*, №3.
Ulaanbaatar, 1970, pp 14-21. [https://doi.org/10.1017/
S1356186304003530](https://doi.org/10.1017/S1356186304003530)

Jambaldorj. *Bolor toli (ded devter)*. Mongol bichigee khörvүүлj, orshil bichij, tailbar khiisen S.Tsolmon, D.Budsuren, D.Nyamaa, S.Amarbayar, P.Byambakhорol. // Mongoliin түүхен survalj bichgiin tsuvral. Boti 22. Ulaanbaatar, 2006.

Jigmеддорж Е. XVI-XVII зууний монголчуудийн оршуулгийн зан үйлийн зарим үүрчлүлт. *Монголчуудийн хойлогийн зан үйл: Уламжлал-орчин уе-чиг хандлага IV. Эрдэм шинжилгээний гуравдугаар хурлын эмкхетгел*. Улаанбаатар, 2023, pp 100-127.

Munkhtulga R, Khurelsukh S, Batbayar T, Badma-Oyu B, Mandakh D. Dundgovi аймгийн Erdenedalai сумийн нутаг Ойут овоо дахи “Golden pogada” XXX-ийн ашиглалтын кhesegt гүйтсетгесен архaeологиин авран кхамгаалakh малтлага судалгааны ајлийн тайлан. Улаанбаатар, 2011, АНГБШ.

Menes G. Khüiten khoshuunii khadnii orshuulga. *Mongolchuudiin garal, ugsaاتnii түүхх: "Paleoethnografiin expedition"-iin kheeriin shinjilgeenii ekh khereglegdekhüün (1986-1989)*. Ulaanbaatar, 2020, pp 76-85.

Улзийбаяр С., Баатархуу Б. XIV-XVII зуunii mongolchuudyn orshuulgyn зан үилин асуудалд (Khatny bulgiin orshuulgyn jisheegeer). *Mongolchuudyn khoilgiin зан үйл: Ulamjal-orchin ue-chig khandlaga. Erdem shinjilgeentii khurlyn emkhetgel*. Ulaanbaatar, 2018, pp 137-154.

Sagan setsen. *Erdeniin товч*. Songomolekh beltgej khörvүүлэг, тайлбар зүүлт khiisen M.Bayarsaikhan. // *Mongolyn түүххөн survival бичгийн tsuvral*. Boti 8. Ulaanbaatar, 2006.

Syo Dakhen. *Mongolyn zan surtakuuuny temdeglel*. (Redaktor D.Ider). Mongolyn dund üyeiin tүүkhend kholbogdokh khyatad survalj bichig. Ulaanbaatar, 2022, pp 42-129.

Turbat Ts, Batsukh D, Batbayar T, Bayarkhuu N, Iderkhangai T. Mongol Altaigas ilersen khadnii orshuulguud. *Studia Archaeologica. Tomus (VI) XXVI, fasc. 14*. Ulaanbaatar, 2008. pp 274-292.

Khurelsukh S, Tsao Jian En, Sun Guo Dun. Byambasuren Kh, Bayarsaikhan Kh, Tsao Pen, Tsai Si. Daraatai shovgoriin khadnii orshuulga. The Ulaanbaatar State University Mongolia. “*Journal of the Archaeology, History and Humanitarian*”. (Volume 16 (15), fasc 8. Ulaanbaatar, 2020. pp 96-103.

Khurelsukh N, Enkhtur A. Khovd aimgiin Duut sumyn tagt yavuulsan archaeologii avran khamgaalakh sudalgaany ajliin tailan. Ulaanbaatar, 2020. AHGBSH.

Khurelsukh S, Enkhtur A. Shar bulgiin amny dursgal. *Archaeological Relics of Mongolia catalogue series. Rock burials of Mongolia. 13 volume.* Ulaanbaatar, 2022. pp 233-241.

Khurelsukh S, Urtnasan E. Umnugobi aimgiin
Nomgon sumyn nutagt yavuulsan archaeologiin avran
khamgaalakh sudalgaanii ajlyn tailan. Ulaanbaatar,
2021. AHGBSH.

Khurelsukh S, Urtnasan E. Avdrant khairkhny dursgal. *Archaeological Relics of Mongolia catalogue series. Rock burials of Mongolia. 13 volume.* Ulaanbaatar, 2022. pp 244-251.

Erdene B. Khovd aimgiin Duut sumyn nutgaas ilersen khünii yasand khiisen paleoanthropologийн судалгаа. Khovd aimgiin Duut sumyn nutagt yavuulsan archaeologийн авран khamgaalakh судалгааны ажлийн тайлан. Улаанбаатар, 2020. pp 44-47. AHGBSH.

Erdene B. Paleoanthropologийн тодорхойлолт: Авдрант хайрхны khadny оршуулгаас илсэн khunii yasnii oldvor. Umnugobi aimgiin Nomgon sumyn nutagt yavuulsan archaelogiin avran khamgaalakh sudalgaany ajлын тайлан. Улаанбаатар, 2021. pp 28. AHGBSH.

Erdenebat U. Khüiten khoshuuny dursgal. *Archaeological Relics of Mongolia catalogue series. Rock burials of Mongolia. 13 volume.* Ulaanbaatar, 2022. pp 262-263.

Erdenebat U, Amartuvshin Ch. *Dugui Tsakhiryin khadny orshuulga (X-XII зуун)*. Ulaanbaatar, 2010.

Erdenebat Ulambayar. Mongol bulshnii sudalгаа. Dundgobi aimagt khiisen archaeologiin sudalгаа: Baga gazryn chuluu. Ulaanbaatar, 2010. pp 313-378.

Ahrens Birte, Nomguunsuren G, Piezonka Henny, Holger Becker, Regina Klee, Michelle Machicek, Bruno Frohlich und Amgalantugs Ts. Das mittelalterliche Höhlengrab von Cagaan Chad, Mongolei. Eine Kriegerbestattung am nördlichen Rand der Wüste Gobi. *Zeitschrift für Archäologie des Mittelalters*. Bonn, 2015. pp 59-126.

Erdenebat U. Altmonolisches Grabbrauchtum - Archäologisch-historische Untersuchungen zu den mongolischen Grabfunden des 11. bis 17. Jahrhunderts in der Mongolei. Dissertation, Rheinische Friedrich-Wilhelms-Universität Bonn (Online-Publikation Bonn 2009: <http://hss.ulb.uni-bonn.de/2009/1958/1958.htm>).



 Open Access This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, adapt, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial.

See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>